



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/24

Мэргэн хошуу

Хагас жилийн мал тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дэх хэсгийн заалт, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/319 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт явагдах хагас жилийн мал тооллогын ажлыг 2025 оны 6 дугаар сарын 4-нөөс 2025 оны 6 дугаар сарын 10-ны хооронд зохион байгуулсугай.

2. Хагас жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	С.Амарболд (Засаг даргын орлогч)
Комиссын орлогч дарга:	П.Ганхэт (Санхүүгийн албаны дарга)
Нарийн бичгийн дарга:	Б.Аззаяа (Төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн)
Гишүүд:	Н.Цэрэнжав (1 дүгээр багийн Засаг дарга)
	Э.Чулуунхүү (2 дугаар багийн Засаг дарга)
	А.Пунцагдорж (3 дугаар багийн Засаг дарга)
	С.Ууганбаяр (4 дүгээр багийн Засаг дарга)
	Ж.Сайнбилэг (Практикал даатгалын төлөөлөгч)

3. Тооллогын ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулан хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг өрх, аж ахуйн нэгжийг тооллогод бүрэн хамруулж түүвэрт хамрагдсан өрхүүдийн тооллогыг видео бичлэг, фото зургаар баталгаажуулан ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Б.Аззаяа)-д хүлээлгэн өгч ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Малын түүвэр судалгаанд хамрагдсан нэгжийн 10-аас доошгүй хувьд хяналтын тооллого явуулж тооллогын үнэн бодит байдлыг баталгаажуулсугай.

5. Комиссын гишүүдийн ажил үүргийн хуваарь гарган, тооллогыг холбогдох хууль тогтоомж, зааврын дагуу зохион байгуулалт сайтай гүйцэтгэж, дүн нэгтгэлийг 2025 оны 6 дугаар сарын 10- ний дотор багтаан сумын комиссын хурлаар хэлэлцүүлэн Аймгийн статистикийн хороонд хүргүүлэхийг комиссын дарга (С.Амарболд)-д үүрэг болгосугай.

2.

6. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ЗДТГ-ын дарга (Ш.Отгонжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.БАТБОЛД